

БАТЛАВ:ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРЭГ ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



.....Н.ЭРДЭНЭХҮҮ

ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
 Гүйцэтгэгч нь Хавдар Судлалын Үндэсний Төвийн газар, барилга байгууламжийн харуул хамгаалалттай холбогдсон үйлчилгээг 24 цагийн туршид хариуцан ажиллах ба дараах ажил үйлчилгээг захиалагчид нийлүүлнэ.

| № | Үзүүлэлт | Тодорхойлолт |
|---|-------------------------------|---|
| 1 | Үйлчилгээ үзүүлэх байршил | УБ хот, БЗДүүрэг, 18-р хороо, Нам-Ян-Жүгийн гудамж 28, Хавдар судлалын үндэсний төв |
| 2 | Ажлын тоо хэмжээ, давтамж | Төвийн 4.0 га газар, 20 000 м.кв бүхий барилга байгууламжуудын дотор болон гадна аюулгүй байдлыг хангах үүргийг 24 цагийн турш тасралтгүй гүйцэтгэх |
| 3 | Үүрэг гүйцэтгэх цэг, давтамж, | 1. Дараах 3 байршилд байрлан 24 цагаар харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэнэ. Үүнд: 1. Төв үүдний хэсэг - 1 ажилтан, 2. Өргөтгөл - 1 ажилтан, 3. Яаралтай тусламжийн төв – 1 ажилтан Эдгээр 3 ажилтан нь дээрх байрлалд өдөр тутам, ээлжээр, тухайн ээлжиндээ 24 цагаар ажил үүрэг гүйцэтгэнэ. 2. Дээрх 3 ажилтныг хариуцсан ээлжийн ахлах ажилтан ажиллах ба ахлах нь өдөр тутам 07.30 цагаас 17.30 цаг хүртэл ажиллана. Ахлах нь харуулуудын үйл ажиллагааг, зохион байгуулах, хянах, дэмжин туслах үүрэгтэй байна. |
| 4 | Үндсэн гүйцэтгэх ажил үүрэг | -Эмнэлгээр үйлчлүүлэгчдийн орох, гарах урсгал хөдөлгөөнд хяналт тавих, зохицуулах, газар, барилга байгууламжид гарч болзошгүй гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, хорлон сүйтгэх үйл ажиллагаа, гал түймэр, хулгай дээрэм болон бусад хэрэг зөрчил, аюул ослын тохиолдолд зохих журмын дагуу хариу арга хэмжээ авч, таслан зогсоох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар бие даан болон байгууллагатай хамтран ажиллах, -Захиалагчын харуул хамгаалалтын үйл ажиллагааны журам, зааврыг дагаж мөрдөх, биелүүлэх -Харуул хамгаалалтын үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлж, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт, гомдол,шаардлага болон илэрсэн зөрчлийг цаг тухайд нь түргэн шуурхай шийдвэрлэх, арилгах үйлчилгээг сайжруулах -Хамгаалалтын ажилтнуудыг тусгай хувцас хэрэгслээр хангах, цэвэр цэмцгэр байлгах, харьцаа хандлага-ёс зүйтэй байлгах, ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой ахуйн болон, эрүүл мэндийн г.м бүхий л асуудлыг бие даан хариуцах -Хамгаалалтын үйл ажиллагаатай холбоотой баримт бичгүүдийг иж бүрэн хөтлөх, үйл ажиллагааны тайлан илтгэлийг тогтмол хөтлөх, бүртгэх, үйл ажиллагааны талаар захиалагчид улирал тутам тайлагнах, эргэх холбоотой ажиллах -Захиалагчын нууцыг чандлан хадгалж, бусдад задруулахгүй байх -Бусад |
| 3 | Нэмэлт ажил үүрэг | Байрлан ажиллах цэгийн дотор, гадна орчны цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан ажиллах, -Шаардлагатай үед байгууллагын удирдлагаас өгсөн үүргийн дагуу төвийн дотоод үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, -Үйлчлүүлэгчдэд холбогдох үнэн зөв мэдээлэл өгөх, эмх журам, дараалал зохицуулах, өвчтөн болон бараа материал зөөвөрлөхөд туслан оролцох, -Эмч, ажиллагсад болон үйлчлүүлэгчдийн автомашинуудыг гадна зогсоолд дэг журамтай байрлуулах, явган зам, зүлэгжүүлсэн хэсэгт автомашинуудыг зогсоохгүй байх зохицуулалтыг хийх |

Хянасан:

ҮАЭД Захирал:

Ц.Уранчимэг

Боловсруулсан:

БМАБА-ны дарга:

Б.Алтанням